



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/240

Номгон

"Гэр хорооллын өрхийг орон сууцжуулах"
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хот, суурийн газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3, 11.1.4, 11.1.5, 11.2 дахь заалт, Орон сууцны тухай хуулийн 8.2.2, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 8/13 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхонгор хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөний дагуу Гэгээншавь 6 дугаар багийн гэр хорооллын өрхийг орон сууцжуулах 2022 оны 8/13 дугаар тогтоолоор баталсан нийт талбайн А хэсгийн 1.5га газарт гэр хорооллын өрхийг орон сууцжуулах ажлыг зохион байгуулсугай.

2. Гэр хорооллын өрхийг орон сууцжуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Энхбаяр

Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Д.Сарангарав

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

С.Байгальмаа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

М.Насанбат

Баянхонгор сумын Засаг дарга

Д.Алтангэрэл

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

А.Цэцэнбилэг

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

С.Хадбаатар

Гэгээншавь багийн Засаг дарга

Т.Ариунтуул

Баянхонгор сумын Газрын даамал

Нарийн бичгийн дарга:

Ц.Баасанбат

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

628010633

3. Гэр хорооллын өрхийг орон сууцжуулах ажлыг холбогдох хууль, журмын дагуу аж ахуйн нэгж, оршин суугч иргэдтэй хамтарч чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-т даалгасугай.

